



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/07

Зуунмод

Газар эзэмших эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.6, 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын 6-р багийн нутаг дэвсгэрт байрлах газар эзэмших эрхийн 0178786 дугаар бүхий гэрчилгээтэй 4110062519 нэгж талбарын дугаартай эмнэлгийн зориулалттай 2445 м² газрыг аймгийн Нэгдсэн эмнэлэг/9059814/-ээс Төв аймгийн Эрүүл мэндийн газар /9061614/-т төрийн байгууллагын албан конторын зориулалтаар Баруун зуунмод 6-р баг, Ирээдүй хотхон, Лувсангомбын гудамж 237 тоот хаягт 15 жилийн хугацаатайгаар эрх шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Эрүүл мэндийн газар /С.Мөнхтуяа/-т дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 369 дүгээр захирамжийн холбогдох хэсэг болон газар эзэмших эрхийн 0178786 дугаартай гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ж.БАТЖАРГАЛ



010004